



Боловсрол, Шинжлэх Ухааны Яамны харьяа

БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

#2 (11)

2023 он

II сар

Сар тутмын хэвлэл

 <http://www.mnier.mn>

Монгол Улсын төлөөлөл олон улсын хамтын ажиллагааны форумд оролцлоо

ШХА-ын санхүүжилтээр хэрэгжиж буй "Тогтвортой хөгжлийн боловсрол-II" төслийн түшиц байгууллага-БСҮХ, хэрэгжүүлэгч БОАЖЯ, БЕГ, БОМСТ ТББ, санхүүжүүлэгч ШХА-ын төлөөлөл энэ сарын 15-16-ны өдрүүдэд Женев хотноо хуралдаж буй Олон улсын хамтын ажиллагааны форумд оролцлоо. 120 гаруй орны төлөөлөгч оролцсон энэ жилийн форум "Ирээдүйн төлөөх боловсрол" сэдвийн дор зохион байгуулагдаж байна.



Швейцарын хөгжлийн агентлагийн (ШХА) хамтран хэрэгжүүлж буй "Тогтвортой хөгжлийн боловсрол-II" төслийн төлөөлөгчид Швейцарын хөгжлийн агентлагийн дэд захирал, Ази, Латин Америк, Карибын орнуудын газрын дарга, Элчин сайд Арно Вики, ШХА-ийн Төв болон Хойд Азийн бүсийн мэргэжилтэн Тиери Умбэр, болон ШХА-ийн Эдийн засаг, боловсролын хэлтсийн дарга Дийпак Элмэр нартай уулзлаа.

Уулзалтаар "Тогтвортой хөгжлийн боловсрол-II" төслийн хэрэгжүүлэгч байгууллагуудын төлөөлөгчид УИХ-гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалангийн ШХА-аас Монгол Улсын боловсролын салбарт оруулж буй хувь нэмрийг үнэлсэн "ТАЛАРХАЛ"-ын бичгийг гардуулав.



"Тогтвортой хөгжлийн боловсрол" төслийн I үе шат 2014-2018 онд үндэсний хэмжээнд хэрэгжсэн бол II үе шат 2019-2023 онд үндэсний болон орон нутгийн түвшинд амжилттай хэрэгжиж байна. Төслийг хэрэгжүүлэгч үндэсний түшиц байгууллагаар Боловсрол судалгааны үндэсний хүрээлэн (БСҮХ), орон нутаг хэрэгжүүлэгч байгууллагаар Байгаль орчны мэдээлэл сургалтын төв (БОМСТ ТББ) ажиллаж байна.

Уг туршилт-судалгаанд сум, аймаг, нийслэлийн 15 бүлгийн 520 сурагч хамрагдах ба цаашид бүх ЕБС-д тухайн платформыг ашиглах боломжийг бүрдүүлэхээр ажиллаж байна.

Монгол Улс ТХБ-оор ЮНЕСКО-гийн ИВЕ байгууллагатай хамтран ажиллаж байна



Тогтвортой хөгжлийн боловсролыг тасралтгүй, хүртээмжтэй явуулснаар үр ашиг гарна. Энэ талаар Швейцарын Холбооны улсын Женев хотноо болсон Олон улсын хамтын ажиллагааны форумар хэлэлцсэн байна. "Ирээдүйн төлөөх боловсрол" сэдвээр болсон тус хурлын талаар болон Швед, Швейцар улсад тогтвортой хөгжлийн боловсролын чиглэлийн мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагаатай танилцаад ирсэн талаараа манай улсын ТХБ-ын Үндэсний багийн төлөөлөл, гишүүд сэтгүүлчдэд мэдээллээ.

Судалгаанд суурилсан боловсролын олон улсын дээрх нээлттэй сангаас Монгол Улсын багш нар ТХБ-ын хичээлийн хөтөлбөртэй танилцан судалж сургалтад ашиглах, туршиж үзэн сайжруулж үр дүн гаргах боломж байгааг тэр бээр хэллээ.

ТХБ-ыг олон нийтэд тэгш, хүртээмжтэй, чанартай хүргэхэд анхаарч ажиллаж буй Европын орнуудын туршлагаас гадна монголчууд хамтарч ажиллах ямар саналтай ирсэн талаар БШУЯ-ны харьяа Боловсролын судалгааны Үндэсний хүрээлэнгийн захирал, доктор М.Итгэлээс тодруулахад, “Бид ЮНЕСКО-гийн IBE буюу Боловсролын Олон улсын лавлах байгууллагын удирдлага, төлөөлөгч нартай хамтын ажиллагааны талаар уулзсан. Боловсролын олон улсын тэргүүлэх чиглэлийн энэ байгууллага улс орнуудын үндэсний хэмжээний ТХБ-ын сургалтын хөтөлбөрийг боловсруулахад тусалдаг. Уг байгууллага 2017 онд үндэсний сургалтын хөтөлбөрийн боловсролын аргачлалыг олон улсад гаргасан.

Үүний дагуу манай Боловсролын судалгааны Үндэсний хүрээлэн шинэ сургалтын хөтөлбөр буюу сургуулийн өмнөх болон ЕБС-ийн сургалтын хөтөлбөрийг боловсруулсан. Энэ чиглэлээр дараагийн шинэ шинэ хөтөлбөр, үзэл баримтлалын дагуу үндсэн сургалтын хөтөлбөрөө боловсруулахад IBE-тай хамтран ажиллаж байна” гэв.



Бодит амьдралд тогтвортой хөгжлийн боловсролыг хангах үйл ажиллагааны нэг жишээг Швейцарын Хөгжлийн агентлагийн Хамтын ажиллагааны Үндэсний зохицуулагч Д.Заяасайхан хэлж байна. Тэр бээр, “Ерөнхий боловсролын сургууль хүлэмжтэй болж, хүүхдүүд төмс, хүнсний ногоо тарьж буй энгийн жишээгээр хэлэхэд үүний цаана байгаль, хүрээлэн буй орчин, эрүүл хооллолт, хүнсний аюулгүй байдлын тогтвортой хэрэглээ гээд эдийн засаг, нийгмийн олон зүйл багтаж тогтвортой хөгжлийн концепцүүд шингэсэн байдаг. Энэ утга агуулгаар ТХБ-ын интеграцчилал явагдаж байдаг” гэлээ. Тэр бээр, Монгол Улсад ТХБ-ын үндэсний онцлогтой бүтэц бүрдсэнийг тодотгож, үйл ажиллагаагаа Швед улсынх шиг ТХБ-ын судалгааны төвтэй болж, түүгээр дамжуулан ТХБ-ыг түгээн дэлгэрүүлэх ажлаа улам эрчимжүүлэх боломжтойг хэлж байна.

"ХУВЬСАЖ БУЙ БОЛОВСРОЛ" МОНГОЛ УЛСЫН АМЛАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ, ЗАМЫН ЗУРАГЛАЛ БОЛОВСРУУЛАХ СЕМИНАР зохион байгуулагдлаа



Ирээдүйн боловсролыг дахин төлөвлөх, ТХБ4-ийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, сурлагын хоцрогдлыг арилгах бодлого чиглэл, арга замыг талуудын оролцоотойгоор тодорхойлох зорилготой “Хувьсаж буй боловсрол (transforming education)” сэдэвт үндэсний хэлэлцүүлгийг 2022 оны 06 сарын 16-07 сарын 05-ны өдөр хүртэл үе шаттайгаар зохион байгуулсан.

Энэ хэлэлцүүлгээс гарсан хувьсаж буй боловсрол Монгол Улсын амлалтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, замын зураглал боловсруулах семинар 2023 оны 2 сарын 24-ны өдөр зохион байгуулагдлаа.



Семинарт БШУЯ, БСҮХ, ИХ ДЭЭД СУРГУУЛЬ, МСҮТ, сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын багш, удирдах ажилтнууд, иргэний нийгэм, аж ахуй нэгж, бизнесийн байгууллага, edtech компаниуд, хэвлэл мэдээлэл, залуучууд, суралцагчдын төлөөлөл оролцов.



Семинар нь дараах чиглэлүүдэд талуудын оролцоотойгоор тодорхойлсон болно.

Чиглэл 1: Цахим шилжилтээр дамжуулан тэгш хамран сургасан, ижил тэгш чанартай боловсролыг хөгжүүлэх

Чиглэл 2: Багш мэргэжлийг хувирган өөрчлөх

Чиглэл 3: Сургалтын хөтөлбөр, арга зүй

Чиглэл 4: Боловсролын ялгаварлал, тэгш бус байдлыг арилгаж, суралцагч эрүүл, аюулгүй орчинд суралцах боломжийг нэмэгдүүлэх

Чиглэл 5: Боловсролын санхүүжилтийн инновац, шинэ схемийг нэвтрүүлэх

Боловсролын салбарыг хувирган өөрчлөхийн тулд оролцогч бүх талыг хамруулах нь чухал бөгөөд сургууль, багш, суралцагч, төр ба хувийн хэвшил, олон нийтийг үүнд татан оролцуулах нь үр дүнд хүрэх үндсэн хүчин зүйл болно.

Багш бэлтгэх их, дээд сургуулийн бакалаврын түвшинд сонгон судлах "МОНГОЛ ДОХИОНЫ ХЭЛ" хичээлийн хөтөлбөрийн хэлэлцүүлэг боллоо.



"МОНГОЛ ДОХИОНЫ ХЭЛ" хичээлийн хөтөлбөрийг хэлэлцүүлж, сайжруулах санал зөвлөмж авах зорилготой



Хөтөлбөрийн хэлэлцүүлгийг Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, сонсголгүйн боловсрол, Монгол үндэсний дохионы хэлний хөгжлийн зөвлөл, дохионы хэлний хэлмэрч орчуулагчдын холбоо, эрт оролцоо цогц хөгжил, тэгш тусгал төрийн бус байгууллагууд хамтран зохион байгуулж, хичээлийн хөтөлбөр боловсруулах багийн гишүүд, Төслийн экспертийн багийн гишүүд, БШУЯ, дэлхийн банк НЕБ, их дээд сургуулийн төлөөлөл, МУБИС,

СӨБС, СЗХҮТ, мэргэжлийн боловсрол ур чадвар олгох сургууль, 29-р сургууль, 186-р цэцэрлэг, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хороо, Монгол улсын сонсголгүй иргэдийн үндэсний холбоо, “бүх нийт боловсролын төлөө” иргэний нийгмийн үндэсний эвсэл гэх мэт байгууллагуудын гишүүд идэвхтэй оролцлоо.

“Монгол дохионы хэл” хичээлийн хөтөлбөрийн хэлэлцүүлгээс

- Сонсголгүй иргэдийн нийгмийн эрх тэгш оролцоог хангах төрийн болон болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааны талаар мэдээлэлтэй болох
- “Монгол дохионы хэл” хичээлийг сонгон судалсан оюутан уг хэлний талаарх мэдлэг ойлголтыг түгээх,
- Сонсголгүй иргэдийг нийгмийн хэл, соёлын цөөнх байдлаар хүлээн зөвшөөрөх, хүндлэх харилцах, нийгэм, соёл, хүний эрхэд суурилсан хандлага нийгэмд түгээн дэлгэрэх гэх мэт үр дүн хүлээж байгаа юм.

ЕБС-ийн сурагчдын математик суралцахуйг дэмжих, багш нарын ажлыг хөнгөвчлөх зорилготой Eduten платформын туршилтын гарааны үнэлгээ хийгдлээ.

Eduten сургалтын платформын гарааны үнэлгээ, туршилтад оролцогчдын бэлэн байдал, хандлагыг илрүүлэх судалгааны ажлыг 2023 оны 2-р сарын 6, 7-нд амжилттай зохион байгууллаа. Гарааны үнэлгээнд туршилтад оролцож байгаа 9, хяналтын 9 сургуулийн нийт 30 бүлгийн 1038 сурагч, 323 эцэг эх, 25 багш, удирдах ажилтан хамрагдсан. Энэхүү гарааны үнэлгээний явцад:

- Туршилтад хамрагдаж байгаа болон хяналтын бүлгийн сурагчдын туршилтын өмнөх мэдлэг, чадварын түвшин тогтоох зорилготой төстийн үнэлгээ (туршилтын 520, хяналтын 518 сурагч)
- Туршилтын сургуулийн багш, удирдлагуудаас туршилтын бэлэн байдал, туршилтын үр дүнгийн төсөөллийг илрүүлэх асуулга, судалгаа
- Туршилтын бүлгүүдийн эцэг эх, асран хамгаалагчдад eduten платформыг танилцуулах мэдээлэл, санал солилцох уулзалт
- Эцэг эхчүүдээс туршилтын туршилтын бэлэн байдал, өмнөх төсөөллийг илрүүлэх асуулга судалгаа

Сургуулийн туршилтын хугацааны ажлын болон сургалтын төлөвлөгөөтэй танилцаж, тулгарч болзошгүй асуудал-шийдэл, туршилтыг үр дүнтэй явуулах боломжийн талаар харилцан санал солилцож, зөвлөгөө өгөв

Туршилтад оролцогч талуудын өмнөх төсөөлөл, туршилтын дараах үр дүнтэй харьцуулах суурь мэдээлэл цуглуулж, нэгтгэв. Мөн эцэг эхчүүд, багш, удирдлагуудтай уулзаж туршилтын зорилго, процесс, платформын ач холбогдлын талаар мэдээлэл, зөвлөгөө өгч, харилцан санал солилцож ойлголтоо нэгтгэв.

“METHODOLOGY & PEDAGOGY TRAINING” дунд хугацааны хөтөлбөр эхэллээ

БСҮХ, Бритиш сургуультай хамтран 3 сарын хугацаанд үргэлжлэх Англи хэлний багш нарын ур чадварыг сайжруулж, заах арга зүйг хөгжүүлж сургагч багш бэлтгэх сургалт 2-р сарын 10-аас эхэллээ. Тус сургалтад хамрагдах 30 багшийг Pearson, Pinnacle, Excel зэрэг хөтөлбөрүүдэд хамрагдаагүй багш нараас сонгосон. Тус багш нар 7 хоногт 3 удаа /ажлын 2 өдөр болон хагас сайн өдөр/ үдээс хойш Улаанбаатар дахь Бритиш сургууль дээр танхимын сургалтад хамрагдах бөгөөд Бритиш сургуулийн Англи хэлний тэнхимийн гадаад багш нар "MPT" хөтөлбөрийн сургалтыг удирдан явуулна. Сургалт нь багш нарын практик ур чадвар, заах арга зүйг сайжруулах, англи хэлний академик мэдлэгийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой гэж Англи хэлний үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх баг үнэлж байна.

Боловсролын салбарынханд зориулсан “ENGLISH READING TEACHERS'-2023” хөтөлбөр

“Бүх нийтийн англи хэлний суралцахуйг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд Mongolian Extensive Reading Association олон улсын Extensive Reading Foundation-ын Монгол дахь салбар гишүүн байгууллага болон БЕГ, БСҮХ хамтран унших арга зүйгээр боловсролын салбарын багш, салбарын удирдах ажилтан болон мэргэжилтэн, ажилтны англи хэлний унших, бичих, ярих, сонсох хэрэглээний чадварыг богино хугацаанд хөгжүүлэхэд чиглэсэн “Англиар уншигч багш нар” хөтөлбөр 2-р сарын 27-оос хэрэгжиж эхэллээ.

АНГЛИ ХЭЛНИЙ БАГШИЙН МЭДЛЭГ, УР ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ДУНД ХУГАЦААНЫ ХӨТӨЛБӨР ЭХЭЛНЭ

Монгол Улсын Засгийн Газраас баталсан "Бүх нийтийн англи хэлний суралцахуйг дэмжих арга хэмжээ" (2022-2025)-г хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу 2023 онд Пинакл академитай хамтран ЕБС-ийн англи хэлний 240 багшийг чадавхжуулах дунд хугацааны хөтөлбөрийг өнөөдрөөс буюу 2023 оны 2-р сарын 13-наас хэрэгжүүлж эхэлнэ.

Энэхүү чадавхжуулах сургалтыг виртуал орчинд интерактив программ дээр TESOL чиглэлээр мэргэшсэн Пинакл академийн америк, канад багш нар удирдан явуулах бөгөөд Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, БЕГ-ын хамтарсан англи хэлний үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх баг сургалтын туршид хяналт, мониторинг хийж ажиллахаар төлөвлөсөн. Language enrichment course (LEC) буюу түвшин ахиулах 102 цагийн эрчимжүүлсэн сургалтад 90 багш, Teacher certification course (TCC) буюу сургагч багш бэлтгэх 92 цагийн эрчимжүүлсэн сургалтад 150 багш тус тус хамрагдана. Чадавхжуулах сургалт нь Пинакл академийн багш нар удирдсан онлайн, интерактив хичээл болон багшийн дэмжлэгтэйгээр сургалтад оролцогчид өөрсдөө бие даан суралцах, англи хэлний заах арга зүй, ерөнхий мэдлэгээ дээшлүүлэх бие даан суралцах хичээл зэргээс бүрдэж байгаа юм. Ийнхүү Монгол улсад анх удаа гадаадын сургалтын байгууллагатай хамтран англи хэлний багшийг чадавхжуулах дунд хугацааны зорилтот, мэдээллийн технологид суурилсан хөтөлбөрийг эхлүүлснээр багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын чанар, үр ашгийг сайжруулж, оролцогчдын эрх тэгш байдлыг хангасан сургалтын загварыг бий болгоход чухал ач холбогдолтой гэж салбарын удирдлагууд үзэж байна.